



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, худалдан авах, зарцуулах, тайлагнах журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх, худалдан авах журам”-ыг нэгдүгээр, “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг зарцуулах, тайлагнах журам”-ыг хоёрдугаар, “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн орлогын бүртгэл”, “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын бүртгэл”, “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг лавлагаа шатлалын эмнэлэгт хүлээлгэн өгөх бүртгэл”, “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн хэрэгцээ, шаардлагыг тооцоолох бүртгэл”-ийн маягыг гуравдугаар, “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээллийн урсгал”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгахыг Санхүү, эдийн засгийн газар (Л.Лувсан), мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ш.Алтантуяа), журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

3. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээллийн сан үүсгэж, тайланг нэгтгэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа), журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Журам батлах тухай” А/563 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



141240060

## ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ, ХУДАЛДАН АВАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрхэд суурилсан гэр бүл төлөвлөлтийн чанартай тусламж, үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй болгох, жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан төлөвлөлтийн тооцооллыг нэвтрүүлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Эрүүл мэндийн байгууллагууд жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэгслээр тасралтгүй хангагдаж, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг тогтвортой үзүүлнэ.

### Хоёр. Журмаар зохицуулагдаж байгаа үйл ажиллагааг дараах байдлаар ойлгоно

- 2.1. Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн эрх: Хосууд болон хувь хүн хэзээ, хэдэн хүүхэд төрүүлэхээ хариуцлагатай шийдэх, энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл авах, гэр бүлээ төлөвлөх, чөлөөт сонголт хийх, жирэмслэхээс сэргийлэх аюулгүй, үр дүн өндөртэй арга, хэрэгсэл болон ялгаварлан гадуурхалтаас ангид, хүндэтгэсэн, нууц хадгалсан, чанартай тусламж, үйлчилгээгээр хангагдахыг;
- 2.2. Гэр бүл төлөвлөлт: Хувь хүн, хосууд эрүүл мэнд, эдийн засаг, амьдралын байдалдаа тохируулан тохиромжтой насандаа жирэмсэлж, эрүүл саруул хүүхэд төрүүлэх, төрөлт хоорондын зайг зөв зохицуулахыг хэлэх ба хэт эрт биш, хэт орой биш, хэт ойрхон биш байх зарчмаар шийдвэр гаргаж, өөрт тохирсон жирэмслэхээс сэргийлэх үр дүнтэй арга хэрэгслээр хангагдан, хэрэглэхийг;
- 2.3. Гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ: Нөхөн үржихүйн насны эмэгтэй, тэдний гэр бүлд жирэмслэхээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх, мэдээлэлтэй сонголт хийх, сонгосон аргуудаар тасралтгүй хангаж, хэрэглээг дэмжих, эмнэл зүйн илрүүлэг хийх, шаардлагатай тохиолдолд жирэмслэхээс сэргийлэх өөр аргад шилжих зэрэг багц тусламж, үйлчилгээг;
- 2.4. Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл: Орчин үеийн арга (Хавсарсан даавар агуулсан эм, дан прогестерон агуулсан эм, тариа, суулгац, яаралтай ууж хэрэглэх эм, ерөндөг, бэлгэвч гэх мэт), мэс заслын арга (эмэгтэйн үр дамжуулах хоолойг боох, эрэгтэйн үрийн суваг боох), уламжлалт арга (Хуанлийн арга, салиа шинжлэх буюу Виллийн арга, биеийн суурь халууныг хэмжих, түр тэвчих арга гэх мэт) хэмээн ангилахыг;
- 2.5. Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгслийн хэрэглээ: Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг тогтмол хэрэглэж байгаа (нөхөр эсвэл түүний хамтран амьдрагч нь хэрэглэдэг) нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувийг илэрхийлсэн үзүүлэлтийг;

2.6. Эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн нас: 15-49 насны эмэгтэйчүүдийг;

2.7. Өсвөр нас: Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тодорхойлсноор 10-19 насныхныг;

**Гурав. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт, худалдан авалт**

3.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь үйлчлэх хүрээний нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд шаардлагатай жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн хэрэгцээ шаардлагын судалгааг гаргахдаа өмнөх жилд хэрэглэсэн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргын улирлын дундаж хэрэглээг тооцоолон тушаалын гуравдугаар хавсралтад заасан “Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн хэрэгцээ, шаардлагыг тооцоолох бүртгэл” маягт /№4/-ын дагуу гаргана.

3.2. Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагын жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн хэрэгцээ шаардлагыг хянана.

3.3. Дүүргийн эрүүл мэндийн төв нь жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн хэрэгцээ шаардлагын судалгааг нийслэлийн эрүүл мэндийн газарт цахимаар хүргүүлнэ.

3.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нийт жилийн хэрэгцээний тоо хэмжээний нэгтгэлд үндэслэн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд зааснаар цахим дэлгүүрээс нийслэл болон орон нутгийн хэмжээнд нэгдсэн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулна.

3.4. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын өгсөн чиглэлийн дагуу жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авч, төлбөрийг шилжүүлнэ.

3.5. Эх барих, эмэгтэйчүүд, үр хөндөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэгслийн нөөцийг байгууллагын төсвөөс бүрдүүлнэ.

**Дөрөв. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцөд тавигдах шаардлага**

4.1. Эрүүл мэндийн байгууллагууд жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн орчин үеийн арга, хэрэгслийн тав ба түүнээс дээш сонголттой, гурваас доошгүй сарын нөөцтэй байна.

4.2. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахад Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын урьдчилан баталгаажуулалтад хамрагдсан байх эсвэл эм, эмнэлгийн хэрэгслийн хатуу зохицуулалттай орны эрх бүхий байгууллагын бүртгэлийн гэрчилгээтэй байна.

- 4.3. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг орлогод авч, тухайн бүтээгдэхүүний онцлог байдалд тохирсон нөхцөлд эмийн санд тавих нийтлэг шаардлага (MNS 5260:2015), эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт түгээлтэд тавих ерөнхий шаардлага (MNS 5530:2014) стандартын дагуу хадгална.

**Тав. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн санхүүжилт**

- 5.1. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагад жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авах үндсэн эх үүсвэр нь эрүүл мэндийн даатгалын сангаас олгож буй нэг иргэнээр тооцсон санхүүжилт байна.
- 5.2. Гадаад, дотоодын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, улсын болон орон нутгийн төсөв, төрийн бус байгууллагын эх үүсвэрийн санхүүжилтээр жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг нэмэлтээр худалдан авалт хийж болно.
- 5.4. Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн тухайн жилийн төсвийн сар, улирлын хуваарьт эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг зардалд тусган харьяа эрүүл мэндийн газарт хүргүүлж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу батлуулна.
- 5.5. Иргэн өөрөө жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авч гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ авч байгаа зардал нь эрүүл мэндийн анхан шатны байгууллагын жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын бүртгэлд хамаарахгүй.



## ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг ханган, цахим мэдээллийн санд бүртгэл мэдээллийг нэгтгэх, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагад хийх хяналт, үнэлгээг боловсронгуй болгохтой холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

### Хоёр. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг бүртгэх, зарцуулах, мэдээллийн цахим сан үүсгэх

- 2.1. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэглээг эрэлхийлж буй эрүүл мэндийн заалттай, алслагдсан бүс нутагт оршин суугаа, өвөрмөц хэрэгцээ бүхий өсвөр насны охид, эмэгтэйчүүд, 0-2 насны хүүхэдтэй хөхүүл эхчүүд, Үндэсний статистикийн хорооноос баталсан аргачлалын дагуу нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээг нэн тэргүүнд үзүүлнэ.
- 2.2. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн орлогын бүртгэл" маягт /№1/-ын дагуу орлогод бүртгэн авна.
- 2.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд үндсэн мэргэшлийн эмчийн тусламж, үйлчилгээ шаардагдах тохиолдолд жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгсэл (ерөндөг, суулгац)-ийг лавлагаа шатлалын эмнэлэгт тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг лавлагаа шатлалын эмнэлэгт хүлээлгэн өгөх бүртгэл" маягт /№3/-ын дагуу бүртгэн өгнө.
- 2.4. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн тандалт мэдээллийн нэгдсэн сан үүсгэх шинэ модуль бүхий цахим програм хөгжүүлэлт хийгдсэн байна.
- 2.5. Мэдээллийн нэгдсэн санд эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн мэдээ, мэдээллийг нэгтгэх, дүгнэх, дүн шинжилгээ хийх, зарцуулалтад хяналт тавих тандалтын тогтолцоо бүрдэнэ.
- 2.5. Иргэдэд олгосон жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг Эрүүл мэндийн сайдын А/611 тоот тушаал (АМ-00)-ын дагуу бүртгэн, Өвчний Олон Улсын 10 дугаар ангиллын Z30 оношийн бүлгийн дагуу програмд оруулна.
- 2.6. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийг олгохдоо эм, эмнэлгийн хэрэгслийн сонголт, гаж нөлөө, хэрэглэх аргын талаар зөвлөгөө, мэдээлэл өгч, тухайн үйлүүлэгч сонголт хийх боломжийг бүрдүүлнэ.

## Гурав. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн тайлагналт

- 3.1. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг нь жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайлан, нөөцийн мэдээллийг тушаалын гуравдугаар хавсралтад заасан "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын бүртгэл" маягт /№2/, Эрүүл мэндийн сайдын А/611 тоот тушаал (ЭМТ 201.11.1)-ын дагуу нэгтгэж улирлын тайланг дараа улирлын эхний сарын 03-ны өдрийн дотор аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төвд цахимаар хүргүүлнэ.
- 3.2. Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлгээс ирүүлсэн тайланд хяналт тавьж, нэгтгэн үйлчлэх хүрээний хүн амын жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайлан, нөөцийн мэдээллийг тушаалын гуравдугаар хавсралтад заасан "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын бүртгэл" маягт /№2/, Эрүүл мэндийн сайдын А/611 тоот тушаал (ЭМТ 201.11.1)-ын дагуу нэгтгэнэ.
- 3.3. Дүүргийн эрүүл мэндийн төв нь улирлын тайланг тушаалын гуравдугаар хавсралтад заасан "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын бүртгэл" маягт /№2/, Эрүүл мэндийн сайдын А/611 тоот тушаал (ЭМТ 201.11.1)-ын дагуу дараа улирлын эхний сарын 05-ны өдрийн дотор нийслэлийн эрүүл мэндийн газарт цахимаар хүргүүлнэ.
- 3.3. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайлан болон нөөцийн мэдээллийг тушаалын гуравдугаар хавсралтад заасан "Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын бүртгэл" маягт /№2/, Эрүүл мэндийн сайдын А/611 тоот тушаал (ЭМТ 201.11.1)-ын дагуу нэгтгэж улирлын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд цахимаар хүргүүлнэ.
- 3.4. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны алба нь Эрүүл мэндийн хөгжлийн төвд жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтын тайланг нэгтгэн Эрүүл мэндийн сайдын А/611 тоот тушаал (ЭМТ 201.11.1)-ын дагуу гаргаж улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор цахимаар хүргүүлж, жилд хоёр удаа тайлангийн тулгалт хийнэ.
- 3.5. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн тайланг нэгтгэж тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, Эрүүл мэндийн сайдын А/611 тоот тушаал (ЭМТ 201.11.1)-ын дагуу дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор цахимаар хүлээн авна.
- 3.6. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь эрүүл мэндийн байгууллагын жилийн тайлангийн нэгтгэлд статистик боловсруулалт хийж, эрүүл мэндийн салбарын үндэсний хэмжээнд гаргах үзүүлэлтийг тооцож, дүгнэлт хийн, эмхэтгэл болгон хэвлүүлж, төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн хороо, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон холбогдох байгууллагуудад дараа жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.
- 3.7. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрүүл мэндийн мэдээллийн алба нь тухайн жилд улсын хэмжээнд хэрэглэсэн жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн

зарцуулалтын тайлан, нөөцийн мэдээллийг нэгтгэн төрийн захиргааны төв байгууллагад дараа оны 04 дүгээр сард багтаан, хүргүүлнэ.

**Дөрөв. Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтад тавих хяналт**

- 4.1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтад жилд 2 удаа хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.
- 4.2. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах гэрээний биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцон, биелэлт хангалтгүй тохиолдолд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт мэдэгдэнэ. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар хууль эрх зүйн хүрээнд шаардлагатай арга хэмжээг авна.
- 4.3. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн зарцуулалтад хяналт тавина.
- 4.4. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв нь гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний чиглэлээр эмч, мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, эрүүл мэндийн байгууллагуудын жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, зарцуулалтад үнэлгээ хийнэ.

Эрүүл мэндийн сайдын 2024 оны  
01 дүгээр сарын 09 өдрийн / / дугаар  
тушаалын гуравдугаар хавсралт



Маягт-1

ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ОРЛОГЫН БҮРТГЭЛ

№	Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тун, хэмжээ марк	Цувралын дугаар	Хүчинтэй хугацаа	Тоо, хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Бэлгэвч (Эмэгтэй)	ширхэг	1	2	3	4	5	6
2	Бэлгэвч (Эрэгтэй)	ширхэг						
3	Хавсарсан даавар агуулсан эм	шахмал						
4	Дан прогестрон агуулсан эм	шахмал						
5	Яаралтай 72 цагийн дотор уух эм	шахмал						
6	Ерөндөг	ширхэг						
7	Суулгац	ширхэг						
8	Тариа	түншил						
9	Бусад (бичих)							

Томьёолол:  
а. Баганы дагуу:  $6 = (4 \times 5)$   
(Нийт үнэ = Тоо хэмжээ x Нэгж үнэ)



Маягт-2

ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАРЦУУЛАЛТЫН БҮРТГЭЛ

Эрүүл мэндийн байгууллагын нэр .....

Улирал .....

№	Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Хорогдол	Эцсийн үлдэгдэл	Иргэдэд олгосон тоо
			1	2	3	4	5	6
1	Бэлгэвч (Эмэгтэй)	ширхэг						
2	Бэлгэвч (Эрэгтэй)	ширхэг						
3	Хавсарсан даавар агуулсан эм	шахмал						
4	Дан прогестрон агуулсан эм	шахмал						
5	Яаралттай 72 цагийн дотор уух эм	шахмал						
6	Ерөндөг	ширхэг						
7	Суулгац	ширхэг						
8	Тариа	түншил						
9	Бусад (Бичих) _____							

**Томъёолол:**

а. Баганы дагуу:  $5 = (1 + 2 - 3 - 4)$   
 (Эцсийн үлдэгдэл = Эхний үлдэгдэл + орлого – зарлага - хорогдол)

Маягт-3

ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙГ ЛАВЛАГАДА ШАТЛАЛЫН ЭМНЭЛЭГТ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ БҮРТГЭЛ

№	Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тун, хэмжээ, марк	Хүчинтэй хугацаа	Хүлээлгэн өгсөн тоо, хэмжээ	Хүлээн авсан огноо	Хүлээн авсан хүний гарын үсэг	Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг
1	Ерөндөг	ширхэг						
2	Суулгац	ширхэг						
3	Тариа	туншил						
4	Бусад (бичих) _____							

ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ЖИЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТООЦООЛОХ БҮРТГЭЛ

№	Жирэмслэхээс сэргийлэх эм, эмнэлгийн хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	А					
			I улирлын хэрэглээ	II улирлын хэрэглээ	III улирлын хэрэглээ	IV улирлын хэрэглээ	Улирлын дундаж хэрэглээ	Жилийн хэрэгцээ шаардлага
1	Бэлгэвч (Эмэгтэй)	ширхэг	1	2	3	4	5	6
2	Бэлгэвч (Эрэгтэй)	ширхэг						
3	Хавсарсан даавар агуулсан эм	шахмал						
4	Дан прогестрон агуулсан эм	шахмал						
5	Яаралтай 72 цагийн дотор уух эм	шахмал						
6	Ерөндөг	ширхэг						
7	Суулгац	ширхэг						
8	Тариа	түншил						
9	Бусад (бичих) _____							

**Томъёолол:**

- Багаанын дагуу:  $5 = (1 + 2 + 3 + 4)$   
(Улирлын дундаж хэрэглээ /эм, эмнэлгийн хэрэгсэл тус бүрээр/ = I улирлын хэрэглээ + II улирлын хэрэглээ + III улирлын хэрэглээ + IV улирлын хэрэглээ)
- Багаанын дагуу:  $6 = (5 \times 5)$   
(Жилийн хэрэгцээ, шаардлага /эм, эмнэлгийн хэрэгсэл тус бүрээр/ = Улирлын дундаж хэрэглээ  $\times$  5 /нийт 4 улирал, 3 сарын нөөцийн тоол/)

0.1 Эрүүл мэндийн сайдын 2024 оны  
дүгээр сарын 09 өдрийн 11 дугаар  
тушаалын дөрөвдүгээр хавсралт

## ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЛИЙН УРСГАЛ

